

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.УРАНЧИМЭГ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

СИТИ СҮЛЖЭЭ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

REN DEWEN

**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ДЭЛГЭР-3” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫН 5 ДУГААР ХҮДРИЙН БИЕТ
АШИГЛАХ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:

СИТИ СҮЛЖЭЭ ХХК-ИЙН

УУРХАЙН ДАРГА

Ө.ОЮУНЧИМЭГ

АГУУЛГА

Агуулга	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Товчилсон үгийн тайлбар	3
1. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Уурхайн нэр, байршил	5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл	5
1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал.....	5
1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал	6
1.5. Уурхайн техник, тоног төхөөрөмж	6
1.6. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө	6
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	7
2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог	7
2.2. Уур амьсгал.....	8
2.3. Гадаргын ус	8
2.4. Газрын доорх ус	8
2.5. Хөрсөн бүрхэвч.....	8
2.6. Ургамлан нөмрөг	9
2.7. Амьтны аймаг.....	Error! Bookmark not defined.
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	11
3.1. Газрын гадарга, хэвлий	11
3.2. Агаарын чанар.....	11
3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус	11
3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг.....	11
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	12
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	22
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	27
5.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	29
5.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2024 оны БОМТ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсөв.....	13
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Error! Bookmark not defined.
Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Error! Bookmark not defined.
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЭБМЗ – Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл

ТЭЗҮ – Техник эдийн засгийн үндэслэл

БОМТ – Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БОЯБ – Биологийн олон янз байдал

УТХГ – Улсын тусгай хамгаалалттай газар

ОХШХ – Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

БОННҮ – Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

ШТС – Шатахуун түгээх станц

БНГ – Байгалийн нөөц газар

ЗДТГ – Засаг даргын тамгын газар

ХХХ – Хувийн хамгаалах хэрэгсэл

1. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Сити Сүлжээ” ХХК-ийн “Дэлгэр-3” нэртэй хайлуур жоншны ордын 5 дугаар хүдрийн биетийг ашиглах уурхайн төсөл нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт оршино. Тус уурхай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 410 км, Хэнтий аймгийн төвөөс зүүн хойш 74 км орчим зайд оршдог.

Уурхайн хүдрийн биет нь Дэлгэрхааны бүлэг ордын Дэлгэр-3 нэртэй талбайн хэсэгт орших бөгөөд геологийн тогтоцын хувьд тухайн хэсэгт нь дээд протерозойн, пермийн, мезозеин болон дөрөвдөгчийн хэсэгт оршино. Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 5, 8-р хүдрийн биетүүдийн зүсэлтүүдээр хязгаарлагдсан 36 орчим га талбайд балансын нөөц нийт 338.2 мян.тн жоншны хүдрийн нөөцтэй. Хүдрийн 5-р биет нь 50-200 м хүртэл гүнд орших ба 65-70 градусын налуу уналттай байна.

Төлөвлөгөөт 2024 оны Уулын ашиглалтын төлөвлөгөөний дагуу 5 дугаар биет дээр 2 түвшинтэй 1 ш босоо гол ам, 2 түвшний 2 ш квершлагаар нээх хувилбараар ажиллуулахаар тусгасан байна.

Энэхүү орд нь дэд бүтцэд харьцангуй ойр байрлалтай, ордоос баруун зүгт 13 км зайд Бэрхийн их уурхай, мөн Өндөрхаан-Бэрхийг холбосон 110 кВ-ийн өндөр хүчдэлийн шугам, ордоос баруун урагш 74 км-т Өндөрхаан-Улаанбаатарыг холбосон хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам зэрэг дэд бүтцийн нөхцлүүдтэй байна.


Уурхайг жилийн турш 210 хоног, хуулийн дагуу 7 цагийн үргэлжлэлтэй 3 ээлжээр ажиллуулна.

Бид өмнөх жилүүдэд компанийн санхүүгийн нөхцөл байдал, дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдэн уурхайн үйл ажиллагааг эхлүүлж чадаагүй бөгөөд 2024 онд эхлүүлэхээр төвлөн ажиллаж байна.

БОННУ-ний хүрээнд уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчилан тодорхойлуулж, ирэх жилүүдийн БОМТ-д төлөвлөгөөнд тусган оруулж, хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна.

1.1. Уурхайн нэр, байршил

“Сити Сүлжээ” ХХК-ийн “Дэ;гэр-3 хайлуур жоншны ордын 5 дугаар хүдрийн биетийг далд уурхайн аргаар ашиглах” төсөл нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 410 км, Хэнтий аймгийн төвөөс зүүн хойш 74 км-т оршиж байна.



Зураг 1. Уурхайн байршил

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр:	“Ситисүлжээ” ХХК
Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар:	5021065
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	Ашигт малтмалын ашиглалт /2008.05.01 - / Гадаад худалдаа
Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж, 35-3 тоот
Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Гүйцэтгэх захирал Ren Dewen, 96620509, Sitisuljee0818@gmail.com
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Уурхайн дарга Ө.Оюунчимэг, 96062389, Sitisuljee0818@gmail.com

1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Дэлгэр-3 жоншны орд нь Бэрхийн уурхайгаас зүүн тийш 13 км зайд оршдог бөгөөд Бэрхийн их уурхай хүртэл 110 кв-н цахилгаан дамжуулах агаарын шугам холбогдсон бөгөөд Дэлгэр-3 орд хүртэл 6 кв-н агаарын шугам мөн холбогдсон. Уурхайн ус хангамжийн эх үүсвэрийн хувьд Дэлгэрхааны ордоос баруун хойш 1.5 км зайд байрлах хайгуул ашиглалтын цооногыг худаг болгон ашиглахаар төлөвлөсөн.

Уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай далд уурхайн нэвтрэлтийн амнууд, өргөх механизм, ажилчдын хотхон зэрэг дэд бүтцийн байгууламжууд баригдаагүй бөгөөд ирэх жилүүдэд барилга, бүтээн байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал

Дэлгэр-3 хайлуур жонш далд уурхайн аргаар олборлох төсөл нь жилд 30.0 мян.т хүдэр олборлох хүчин чадалтайгаар 6.2 жил үйл ажиллагаа явуулахаар Техник эдийн засгийн үнэлгээнд тусгасан байна. Энэхүү уурхайн 6.2 жилийн 2 сар нь дэд бүтэц бүтээн байгуулалт, бэлтгэл шатны арга хэмжээнд зарцуулагдах бөгөөд тухайн арга хэмжээг төлөвлөгөөт жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Уурхай нь олборлосон хайлуур жоншны хүдрийг төслийн талбайгаас баруун урагш 221 км зайд, Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт байрлах “Хөх Бишрэлт” ХХК-н жонш баяжуулах үйлдвэрт нийлүүлнэ.

1.5. Уурхайн техник, тоног төхөөрөмж

Дэлгэр-3 хайлуур жоншны ордын 5 болон 8 дугаар хүдрийн биетийг далд аргаар олборлон ашиглах бөгөөд олборлосон хүдрийг газрын гадарга дээр анхан шатны бутлалт болон гар ялгалтыг хийнэ.

Хайлуур жоншны ордын 5 болон 8 дугаар хүдрийн биетийг далд аргаар олборлон ашиглах төсөл нь уурхайн босоо ам болон бэлтгэл, огтлох малталт нэвтэрнэ. Далд уурхайн олборлолтын үйл ажиллагаанд мөргөцөгт хүдэр нурааж олборлох бөгөөд үүнд өрөмдлөг – тэсэлгээний аргыг хэрэглэнэ.

Далд уурхайн ашиглалтын тоног төхөөрөмжид арын ачилттай ачигч машин, тэргэнцэр, агааржуулалтын сэнснүүд, клеть, шкив зэрэг болно.

Уурхайн олборлолт болон ашиглалтын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд нь доорх болно. Үүнд:

- Зүтгүүр, СТУ-2.5/6G
- Утгуурт ачигч ZL30
- Z-17AW маркийн ачигч машин
- Тэргэнцэр УВГ-0.7
- Уурхайн өрмийн машин, УТ-28
- Компрессор 7ВКМ-25/8
- Гол сэнсний төхөөрөмж, ВОК1
- Туслах сэнсний төхөөрөмж, СВМ-4М
- Автосамосвал, 25тн,


1.6. Тухайн жилийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Төлөвлөгөөт жилд зөвхөн 5-р хүдрийн биетэд ашиглалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд жилд 30.0 мян.тн буюу 11.72 мян.м³ хүдэр олборлохоор ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна. .

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог

“Сити Сүлжээ” ХХК-ийн “Дэлгэр-3” хайлуур жоншны ордын 5 дугаар хүдрийн биет ашиглах төсөл нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 410 км, Хэнтий аймгийн төвөөс зүүн хойш 74 км-т оршиж байна. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болох Хэнтий аймгийн Батноров сум нь Хэнтийн нуруу захын салбар уулсын нэг хэсэг болох Эрээн давааны баруун хэсэг Өлзий Сайханы нуруу орших бөгөөд төдийлөн өндөр биш, уулс нь хэд хэдэн болон салаалсан байдаг. Батноров сумын газар нутаг нийтдээ нам өргөгдсөн учир ихэвчлэн цав тологодын хэв шинж бүхий хотгор гүдгэр зонхилох бөгөөд эдгээр толгудын үнэмлэхгүй өндөр нь 1000-1500 метр, харин харьцах өндөр 20 – 30 метрээс 100 гаруй метр байдаг байна.



Зураг 2. Батноров сумын гадаргын өндөршил

2.2. Уур амьсгал

“Сити Сүлжээ” ХХК-ийн “Дэлгэр-3” хайлуур жонш ашиглах төсөл байрлах Хэнтий аймгийн Батноров сум нь уур амьсгалын хувьд эрс тэрс, зундаа +40 хэм хүртэл халж, өвөлдөө -30-аас -38 хүрч хүйтэрдэг. Жилд дунджаар 200-300 мм хур тунадас унадаг тул харьцангуй хуурай бөгөөд ихэнх хур тунадас зуны улиралд ордог зүй тогтолтой. Батноров сум нь хээрийн бүсэд оршдог учир тул хавар намрын агаарын урсгалын тогтворгүй үед хавсарга салхи ихтэй байх бөгөөд өвөл харьцангуй дулаан салхи багатай байна.

2.3. Гадаргын ус

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Хэрлэн голын сав газарт хамаарах бөгөөд тогтмол ундаргатай, гадагш урсац бүхий гадаргын ус байхгүй. Энэ нутагт зөвхөн хур бороо, хайлсан цас мөсний усаар тэжээгдэх сайр, ул хөрсний усны түр зуурын тэжээлтэй сайр-горхи тохиолдоно. Дэлгэр-3 хайлуур жоншны ордтой хамгийн ойр гадаргын ус нь Хэрлэн гол гэж тооцогдох бөгөөд хэрлэн гол нь Төв, Хэнтий, Дорнод аймгийн нутгийг дамжин урсдаг.

2.4. Газрын доорх ус


Орд орчмын талбай ба зэргэлдээх ордууд дээр олон дахин гидрогеологийн янз бүрийн ажиглалт, туршилтын ажлуудыг хийсэн байдаг

Региональ гидрогеологийн хувьд Хэрлэнгийн ай савын нутаг дэвсгэр дээр ус агуулагч доорхи үе давхарга, бүрдэл, бүс (5.8-р зураг буюу хавсаргалт зураг 8) тархсан байна. Үүнд:

1. Голоцений настай, аллювийн гаралтай хурдас доторхи ус агуулагч үе давхарга,
2. Голоцений настай, нуурын гаралтай хурдас доторхи ус агуулагч үе,
3. Плейстоцений настай, аллюви-пролювийн гаралтай хурдас доторхи ус агуулагч бүрдэл,
4. Неогений настай, эх газар-эх газрын нуурын гаралтай хурдас доторхи ус агуулагч бүрдэл,
5. Дээд цэрдийн настай, эх газар-эх газрын нуурын гаралтай хурдас доторхи ус агуулагч бүрдэл,
6. Доод цэрдийн настай, эх газрын нуурын гаралтай хурдас доторхи ус агуулагч бүрдэл,
7. Юра, Триас, Пермийн настай, тунамал чулуулаг дахь ус агуулагч үе давхаргат-ан цавлаг бүс,
8. Пермээс өмнөх насны тунамал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс,
9. Түрмэл чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс,
10. Бялхмал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс,
11. Хувирмал чулуулуг дахь ус агуулагч ан цавлаг бүс,
12. Карбонат чулуулаг дахь ус агуулагч хөндийлжилт- ан цавлаг бүс.

2.5. Хөрсөн бүрхэвч


Төсөл хэрэгжих газар нутаг нь уулын хар хүрэн, хүрэн, нугын хүрэн, голын хагшаас хурдаст хөрстэй гэж тэмдэглэгдсэн бөгөөд нутгийн ихэнх хэсэгт хээрийн бүсэд зонхилох хүрэн хөрс тархсан. Нутгийн ихэнх хэсэгт уулын хөрс тархсан бөгөөд өмнөд хэсгээр нам уул ухаа толгодын хөрс зонхилон гол горхи дагуу тал хөндийн болон чийгт гарлын хөрс тархана.



Зураг 3. Батноров сумын хөрс

2.6. Ургамлан нөмрөг

Төслийн талбай орших Батноров сумын ихэнх нутаг нь уулын ойт хээрт хамаарах бөгөөд сүүлийн жилүүдэд энэ бүс нэлээд багасаж ой ихээр түймэрт автах болсон. Хээрийн ба хуурай хээрийн ургамал сүүлийн жилүүдэд ойт хээрийн ургамал руу түрэн орох болсон нь уур амьсгалын дулааралтай холбоотой юм. Нутгийн хойд уулархаг хэсгээр хус, бургас, улиас, яргай, хайлаас, гацуур зэрэг жижиг ой төгөлтэй, нохойн хошуу, дэгд, тарваган шийр, цөс өвс, таван салаа, сөд, бамбай, уулын цагаан төмс зэрэг эмийн ургамал, уул, хээрийн хялганат хиаг, үетэй хялганат, шивээт хялгана, түнхлээ, хиаг, саман ерхөг, цэцэгт дааган сүүл гэх мэт бэлчээрийн ургамал зонхилон ургадаг.



Зураг 4. Батноров сумын ургамлын ангилал

2.7. Амьтны аймаг

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчинд хуурай хээр болон хуурай хээрийн экосистем тархсан.

Амьтны аймгийн хувьд тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, дорго, мануул, шилүүс, туулай, чандаг зэрэг ан амьтад, шонхор, тас, сар, хур, сойр, шаазгай, ятуу, болжмор, хараацай, усны шувуудаас тогоруу, галуу, ангир, хун, нугас зэрэг жигүүртэн шувуудтай. Хэрлэн голд сөөм булуу цагаан, зэвгэ, цурхай зэрэг загастай, Тогоруу, хун, галуу, нугас, ангир зэрэг усны шувууд, шар шувуу, шонхор, тас, сар, хур, сойр, ятуу, болжмор, хэрээ, хараацай шувууд нутагладаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Дэлгэр-3” хайлуур жоншны орд ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд төслөөс байгаль орчны бүрдэл хэсгүүд болох газрын гадарга, хэвлий, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал зэрэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тусгаж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

3.1. Газрын гадарга, хэвлий

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг товч дурдвал:

- Барилгажилт, дэд бүтэц барьж байгуулах болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хэвлийн хэлбэр дүрс өөрчлөгдөх
- Хөнгөн тэрэг, уурхайн ашиглалтын машин механизмын хөдөлгөөнд зориулан уурхайн дотоод болон гадаад тээвэрлэлтийн зам байгуулах, үүнээс үүдэн газрын гадарга, хэвлийд өөрчлөлт орох.

3.2. Агаарын чанар

Уурхайн талбайд анхан шатны бутлалт хийх, шигшүүр ажиллах, хүдэр түр хадгалах талбай зэрэг бүхий л шат дамжлагуудаас тоос тоосонцор үүсдэг. Мөн идэвхтэй овоолго, эвдрэлд орсон талбай зэргээс хуурай салхитай үед тоос шороо агаарт дэгдэж салхины дагуу тархах зэрэг нь төслийн үйл ажиллагаанаас агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл болж болзошгүй юм.

3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл нь шатах тослох материал, хатуу болон шингэн хог хаягдлын талбайгаас бохирдол үүсэх зэрэг юм.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл нь шинээр шимт хөрсний хуулалт хийгдэх газарт үүсэх хөрсний эвдрэл ба бүтэцийн алдагдал, уурхайн дотоод замаар зорчих техникийн нөлөөгөөр үүсэх өнгөн хөрсний талхагдал, төслийн талбайгаас үүсэх тоосонцорын тархалт гэсэн өдөр тутамд үүсч байгаа сөрөг нөлөөллөөс гадна авто зогсоол ба засвар үйлчилгээний талбай орчимд үүсэх шатах тослох материалын цэгэн бохирдол, ахуйн гаралтай органик ба хатуу, шингэн хог хаягдлаас үүдэлтэй механик болон нянгийн бохирдол гэсэн болзошгүй сөрөг нөлөөллүүд байна.

3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дуу чимээнээс амьтад дайжих, зам, дэд бүтэц байгуулснаас үүдэн амьдрах орчин алдагдах зэрэг болно.

Харин ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дэд бүтэц, барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэн ургамлан нөмрөг талхлагдах юм.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Сити Сүлжээ” ХХК нь хайлуур жоншны “Дэлгэр-3” ордыг ашиглах төсөл явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг боломжит хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн талуудын оролцоог хангасан хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж мөн нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Бид 2024 онд гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Төслийн 2024 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа, жонш олборлолтын үйл ажиллагаа, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, олборлосон хүдрийн тээвэрлэлт зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Бид 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгож, үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн болно.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь тусгай зөвшөөрөлтэй талбай, түүнээс гадна ОХШХ-т багтсан хяналт шинжилгээний цэгүүд хамаарна.

5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн 2024 оны БОМТ-ний гол зорилгод үйл ажиллагаанаас үүсэх, гарч болзошгүй эрсдэлүүдийг бүрэн тодорхойлж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршиж байгаа болно.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэргийг агуулсан 49 гаруй төсөвт болон төсөвт бус ажилтай болно.

Төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалд **145,000,000.0 (Нэг зуун дөчин таван сая төгрөг)** төгрөг төсөвлөгдсөн.

Хүснэгт 1. 2024 оны БОМТ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсөв

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал	Нэмэлт тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	35'000'000	
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	30'000'000	
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20'000'000	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	3'000'000	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2'000'000	
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	23'600'000	
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	23'400'000	
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2'000'000	
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4'980'000	
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	1'020'000	
2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төг		145'000'000.0	

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” түүний хавсралтад төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваан агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн энэхүү төлөвлөгөөг боловсрууллаа.

БОННУ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2024 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй 12 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Аргачлал, стандарт, эрх зүйн зохицуулалт
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Агаар									
1	Олон салаа зам гаргах	Олон салаа зам гаргахаас сэргийлэх шаардлагагүй замыг хаах, тэмдэг байрлуулах, хурдны хязгаар тогтоох	Уурхайн талбай	Км	-	Уурхайн бэлтгэл үйл ажиллагааны хүрээнд зам байгуулах учир хэмжээ тодорхойгүй байна.	8'000'000	Тухай бүр	Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль
2	Машин, техникийн хөдөлгөөнөөс тоос босох	Уурхайн тоос босох боломжтой байршлуудад тоосны болон агаарын бохирдлын хэмжилтийг тогтмол хийх. Стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Уурхайн технологийн зам орчим	км	-		3'000'000	Улирал тутам	МУ-ын болон уурхайн замын хөдөлгөөний журам
3		Тоосны хэмжилт гүйцэтгэх хяналтын цэгүүдийн байршлыг тогтоож, тогтмол хугацаанд зөврийн багаж ашиглан хэмжилт хийнэ		км	-		2'000'000	Төлөвлөгөөт жилд	Агаарын тухай хууль
4	Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж гарах хий агаарын чанарт нөлөөлөл	Суурин тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх	Хүдэр бутлах төхөөрөмж орчим	Тоос босох талбай	1'000'000		5000 км тутамд		
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Хөрс									
5	Хөрс хуулагдах	Бүтээн байгуулалтын арга хэмжээний хүрээнд шинээр газар хөндөх үйл ажиллагаа явуулах үед шимт хөрсийг холбогдох стандартын дагуу хуулах	Хөрс хуулах газар				5'000'000	Төлөвлөгөөт жилд	MNS 5916:2008
6		Хуулж авсан шимт хөрсийг зориулалтын овоолгод MNS 5916:2008 стандартын шаардлагын дагуу 5 метрээс дээшгүй өндөртэй овоолон хадгалах	Шимт хөрсний овоолго				3'000'000	Төлөвлөгөөт жилд	
7	Тос, тосолгоо, түлш, хөрсөнд асгарч хөрсийг бохирдуулах	Аливаа асгаралтаас урьдчилан сэргийлж техник хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх	Хөнгөн тэрэг				2'000'000	5000 км тутам	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

*“Дэлгэр-3” хайлуур эжонинь ордын 5 дугаар хүдрийн биет ашиглах төслийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Аргачлал, стандарт, эрх зүйн зохицуулалт
8		ШТС-г байнгын хяналтад байлгаж өдөр тутмын үзлэг хийх	ШТС	Үзлэг	-	Өдөр тутам	500,000.0	Өдөр тутам	-
9		Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх	Хөнгөн тэрэг, машин механизм	ш	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
10		Асгаралттай тэмцэх иж бүрдэл шаардлагатай газруудад байрлуулах	Засварын талбай	ш	500,000.0	2	1,000,000.0	Төлөвлөгөөт жилд	
11		Нийт ажилтан, ажиллагсадад асгаралт болохоос урьдчилан сэргийлэх үүднээс АА-ны хурлуудыг зохион байгуулах	Уурхайн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Өдөр тутам	-
12		Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтын үед баримталж ажиллах компаний дотоод журмыг боловсруулах	Уурхайн талбай	-	-	-		Төлөвлөгөөт жилд	-
13		Уурхайн бүх тээврийн хэрэгслийг улсын техникийн үзлэгт хамруулах	Хөнгөн тэрэг, машин механизм	ш	-	-		Тухай бүрд	-
14	Хог хаягдал ил задгай хаягдах	Хог хаягдлын менежментийн компаний дотоод журмыг боловсруулах	Хог хаягдлын цэг	-	-	1		Төлөвлөгөөт жилд	Хог хаягдлын тухай хууль
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Газрын доорх ус									
15	Усны нөөц хомсдох	Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах	Ашиглалтын худаг	-			500,000.0	Төлөвлөгөөт жилд	Усны тухай хууль
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Ургамал									
16	Ургамлын нөөц хомсдох, ховор ургамал устгах	Уурхайн талбайд нэн ховор, ховор зүйлийн ургамал таарсан тохиолдолд шилжүүлэн суулгах арга хэмжээ авах	Уурхайн нийт талбай	-			300,000.0	Тухай бүрд	Байгалийн ургамлын тухай хууль
17	Ургамлын ургах нөхцөл багасах	Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх	Хөндөгдөх газар	-			4'000'000	Тухай бүрд	

№	Сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажил	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Аргачлал, стандарт, эрх зүйн зохицуулалт
18	Тал хээрийн түймэр ургамлан нөмрөгт нөлөөлөх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх	Гал түймэр тохиож болох газар орчимд		Дотоод үйл ажиллагаа			Сар бүр	
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Амьтан									
19	Уурхайн үйл ажиллагаанаас зэрлэг амьтанд нөлөөлөх	Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх	Төслийн хашаа	м	-	-	-	Сар бүр	Амьтны тухай хууль
Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг: Бусад									
20	Хог хаягдал ил задгай хаягдах	Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгах, байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр түр хадгалах цэг байгуулах, тухайн цэгийг сумын Засаг даргаас заалгаж захирамж гаргуулан авах	Хог хаягдлын цэг	-	-	-	4'700'000	Төлөвлөгөөт жилд	Хог хаягдлын тухай хууль
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДЭД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮДИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ						35,000,000			

5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Бид 2024 онд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хүрээнд нийт 2 ажил төлөвлөөд байна. Хүснэгт 3-аас харна уу.

Төлөвлөгөөт жилийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд дараа дараагийн жилийн нөхөн сэргээлтэд ашиглах шимт хөрсийг бэлдэх, холбогдох стандартын дагуу хадгалах, хадгалж буй шимт хөрсний үржил шим, хэмжээг алдагдуулахгүй байх арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Шинээр хөндөгдөж буй газраас шимт хөрсийг хуулж, овоолгод хадгалах. Хөндөгдөх газар бүрт байгаль орчны мэргэжилтэн үзлэг хийж хуулах шимт хөрсний зузааныг тодорхойлно.	га	3.21	10'700'000		Тухай бүрд	MNS 5916:2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Холбогдох стандартын шаардлагын хүрээнд шимт хөрсний овоолгын үржил шим, хэмжээг алдагдуулахгүйн тулд ургамалжуулалтын арга хэмжээг эхлүүлэх	га	-	19'300'000		Тухай бүрд	MNS 5916:2008
2024 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ НИЙТ ЗАРДАЛ					30'000'000			

5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Сити Сүлжээ ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулах	Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалах хэрэгжих газар нутаг	-		20'000'000	Төлөвлөгөөт жилд	-
2024 ОНЫ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ				20'000'000				

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Сити Сүлжээ” ХХК-ийн “Дэлгэр-3” хайлуур жоншны ордын 5 дугаар хүдрийн биет ашиглах төсөл нь төлөвлөгөөт жилд үйл ажиллагаа эхлүүлэхээр төлөвлөж буй төсөл юм. Төлөвлөгөөт жилд төслийн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай айл өрхийн судалгааг гаргах, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нийлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Лицензийн талбайн доторх айл	Уурхайн талбайн нөлөөллийн бүсийг тодорхойлох. Тухайн нөлөөллийн бүсэд газар эзэмшиж, байрлан амьдарч буй орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг эхлүүлэх хүсэлт гаргах	-Нөлөөлөлд өртөх айл, өрх	Тодорхойгүй	-	3'000'000	Төлөвлөгөөт жилд	-
2024 ОНЫ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ						3'000'000		

5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2024 оны БОМТ-д биет болон биет бус өвийг хамгаалах чиглэлээр 2 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биет бус өв	Батноров сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өврүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх	Батноров сум	1	2'000'000	2'000'000	Төлөвлөгөөт жилд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Журам	Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах	-	1	Үйл ажиллагааны зардлаас		Төлөвлөгөөт жилд	/шинэчилсэн найруулга/, 27.8
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ НИЙТ ЗАРДАЛ					2'000'000 ₮			

5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Дэлгэр-3 хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагаа бэлтгэл үе шат буюу барилгажилт дэд бүтцийн бүтээн байгуулалтууд энэ онд хийгдэхээр төлөвлөгдөөд байгаа.

Уурхайлалтын энэ үе шатанд эрсдлүүдийг дараах байдлаар ангилан урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг нэг бүрчлэн төлөвлөсөн болно.

1. Автомашин, тээврийн хэрэгслийн осол
2. Гал түймрийн эрсдэл
3. Тэсрэх бодисын эрсдэл
4. Хүний эрүүл мэндэд гарч болох эрсдэл

Тодорхойлсон эрсдэлүүдийг бууруулах, урьдчилан сэргийлэх 7 арга хэмжээг төлөвлөвлөн холбогдох хууль эрхзүйн бодлогын зохицуулалт, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын хамт дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй, аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа ба давтамж	Эрх зүйн зохицуулалт журам	
1	Уурхайн болзошгүй осол	Далд уурхайн аваар устгах төлөвлөгөө боловруулж, холбогдох газраар батлуулах	Уурхайн талбай	3'000'000			Төлөвлөгөөт жилд		
2		Уурхайн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас			Төлөвлөгөөт жилд		
3		Уурхайн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох	Уурхайн талбай	1	3'000'000	3'000'000		Төлөвлөгөөт жилд	
4	Тэсрэх бодис	Тэсрэх бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх	Тэсрэх бодисын ашиглалтын явцад						
22	Галын аюул	Уурхай орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох	Уурхай орчимд	-	3'000'000				
23		Гал түймрийн үед хэрэглэх галын булангуудыг байгуулж, үзлэг хийж, багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийн бүрэн байдлыг шалгана.	Уурхай орчимд	2	300'000	600'000		Төлөвлөгөөт жилд	
24		Технологийн дагуу тэсрэх бодисын агуулахыг барьж ашиглатанд оруулах	Уурхай орчимд		14'000'000				
2024 ОНЫ ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН НИЙТ ЗАРДАЛ					23'600'000				

5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бид 2024 оны БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлана.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн талбайн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээнүүдийг төлөвлөгөөт жилийн БОМТ-д тусган оруулав. \ Хог хаягдлын менежментийн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын менежментийн арга хэмжээ	Цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Энгийн хог хаягдал	Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг холбогдох зөвшөөрөл бүхий байгууллагатай байгуулан, ахуйн хог хаягдал зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Уурхайн талбайд		17'500'000			Төлөвлөгөөт жилд	Монгол улсын хог хаягдлын тухай хууль, түүнтэй холбоотой журам, стандартууд
2		Шаардлагатай газруудад хогийн сав байрлуулах	Хог хаягдлын түр цэгүүд	ш	40'000-	60	2'400'000	Тухай бүрд	
3		Төслийн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих	Уурхайн талбайд		3'000'000		-	Тухай бүрд	
19	Хог хаягдлын тоо бүртгэл хөтлөх	Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлнэ	Төслийн талбай		500'000		-	12 сард	
2024 ОНЫ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН НИЙТ ЗАРДАЛ						23,400,000			

5.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Бид төлөвлөгөөт жилд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд нийт 6 төсөвт болон төсөвт бус арга хэмжээ төлөвлөөд байна. Тухайн арга хэмжээнүүдийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	
1	Зөвлөх үйлчилгээний ААН-тэй гэрээлэх	Дотоод үйл ажиллагаа	Төлөвлөгөөт жилд	Байгаль орчны хэлтэс	
2	Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах	1'000'000	Төлөвлөгөөт жилд		
4	Ногоон байгууламж	1'000'000	Төлөвлөгөөт жилд		
5	Бичиг баримт	Аймгийн Засаг даргаар тээврийн замын маршрутыг тогтоолгох	Дотоод үйл ажиллагаа		Төлөвлөгөөт жилд
6		Экологийн паспорт хөтлөх	Дотоод үйл ажиллагаа		Төлөвлөгөөт жилд
7	Орон нутаг, хамтын ажиллагаа	Дотоод үйл ажиллагаа	Тайлант жилд		
2024 ОНЫ УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ			2'000'000		

5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, тэдгээрийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал болон холбогдон гарах зардлуудыг урьдчилан тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулан хүснэгт 10-д нэгтгэн үзүүлэв.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүнг тухайн жилийн тайландаа тусган ажиллахаас гадна улирал тутам ус, хөрсний дээжний шинжилгээний хариуг зохих газруудад хүргүүлэн ажиллана.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Экологийн бүрдэл хэсгүүд	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн нэр байршил		Хугацаа ба Давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Зөвшөөрөгдөх хэмжээ/Баримтлах стандарт
			Хяналт шинжилгээний цэгүүдийн дугаар/код	Дээж авах байршил, координат /49N /					
1	Агаар	Хүчилтөрөгч (O ₂); Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO); Азотын давхар исэл (NO ₂); Циант устөрөгч (HCN); Хүхэрлэг хий (SO ₂); Агаар дах PM10, хэмжээтэй тоосонцор; Агаар дах PM2.5 хэмжээтэй тоосонцор; Дуу чимээ;	AQD-1	Тодорхойгүй	Жилд 2 удаа	2 удаа	160'000	960,000.00	Агаарын чанар. MNS 4585:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 5885:2008 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 17.2.3.16-88 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 4048:88
2			AQD-2	Тодорхойгүй			160'000		
3			AQD-3	Тодорхойгүй			160'000		
20	Хөрс	pH, Хөнгөнцагаан/Al/; Калци/Ca/; Магни/Mg/; Кали/K/; Төмөр нийт/Fetotal/; Хүнцэл/As/; Бари/Ba/; Берилли/Be/; Бисмут/Bi/; Кадми/Cd/; Кобальт/Co/; Хром/Cr/; Зэс/Cu/; Лантан/La/; Лити/Li/; Манган/Mn/; Молбиден/Mo/; Никель/Ni/; Фосфор/P/; Хар тугалга/Pb/; Сурьма/Sb/; Селен/Se/; Стронци/Sr/; Титан/Ti/; Ванади/V/; Иттрий/Y/; Цайр/Zn/; Циркони/Zr/;	SMP-1	Тодорхойгүй	Жилд 2 удаа	2 удаа	210000	1,260,000.00	MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 3298-90. Хөрсний дээжлэлтэд тавих ерөнхий шаардлагууд; Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297-91
21			SMP-2	Тодорхойгүй			210000		
22			SMP-3	Тодорхойгүй			210000		
45	Гүний ус	pH, Кали, /K+/; Натри, /Na+/; Кальци, /Ca2+/; Магни, /Mg2+/; Хлорид, /Cl-/; Нитрит, /NO2-/; Нитрат, /NO3-/; Карбонат, /CO32-/; Гидрокарбонат, /HCO32-/; Нийт хатуулаг, /Нийт хатуулаг/; Хуурай үлдэгдэл, /TDS/; Мөнгө, /Ag/; Хөнгөнцагаан, /Al/; Мышьяк,	WMP-1	Тодорхойгүй	Жилд 2 удаа	2 удаа	460000	2'760,000.00	Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010 Усан орчны чанарын үзүүдэлт.
46			WMP-2	Тодорхойгүй			460000		

**“Дэлгэр-3” хайлуур эжонини ордын 5 дугаар хүдрийн биет ашиглах төслийн 2024 оны
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

47	/As/; Бари, /Ba/; Кадми, /Cd/; Кобальт, /Co/; Хром, /Cr/; Зэс, /Cu/; Төмөр, /Fe/; Манган, /Mn/; Молибден, /Mo/; Никель, /Ni/; Хартугалга, /Pb/; Цайр, /Zn/; Уран, /U/	WMP-3	Тодорхойгүй		460000	Ерөнхий шаардлага. MNS 4586:1998 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2015
2024 ОНЫ ОХШХ-ИЙН НИЙТ ЗАРДАЛ		4'980'000				

Хүснэгт 11. ОХШХ-ийн хүрээнд хийгдэх ажлууд

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа Давтамж	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг
1	Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд ус, хөрс, агаар, ургамал, амьтны дээжлэлт, хэмжилт, шинжилгээ хийх хяналтын цэгүүдийн байршлыг тодорхойлох, тухайн цэгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, кодлол болон дугаарлалтын систем бий болгох	Төлөвлөгөөт жилд	Агаар
2	Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар гүйцэтгэх, үр дүнг боловсруулах	Жилд 2 удаа	Агаар
3	Хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх	Жилд 2 удаа	Хөрс
4	Ундны усны дээж авч химийн болон бактерлогийн үзүүлэлтийг шинжлүүлэх	Жилд 2 удаа	Ундны ус

5.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж, нээлттэй байх, хамтран ажиллах зарчмыг “Сити Сүлжээ” ХХК баримтан ажиллана.

2024 онд бид нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээний хүрээнд доорх арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах	520'000	6-9 сард	Байгаль орчны хэлтэс
2	Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулах (орон нутагтай хамтран ажиллах гэрээний 3.1.10-н хүрээнд)	500'000	Тогтмол	
2024 ОНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ		1'020'000		